



INTERNATIONAL MONETARY FUND



Хэвлэлийн мэдээлэл № 17/54
ШУУД ТҮГЭЭХ
2017 оны 2-р сарын 19

Олон Улсын Валютын Сан
Вашингтон, К.Т. 20431 АНУ

ОУВС Монгол Улстай гурван жилийн хугацаатай өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн тохиролцоонд ажлын хэсгийн түвшинд хүрлээ

Ажлын хэсгийн айлчлалын төгсгөлд гаргаж байгаа хэвлэлийн мэдээлэл нь тухайн улсад ажилласан ОУВС-гийн мэргэжилтнүүдийн хийж гүйцэтгэсэн ажлын урьдчилсан үр дүнг танилцуулах зорилготой юм. Энэхүү мэдэгдэлд тусгасан байр суурь нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийнх бөгөөд ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн байр суурийг илэрхийлэх албагүй юм. Танилцуулсан урьдчилсан үр дүнд үндэслэн ажлын хэсэг тайлан бэлтгэх бөгөөд тайланг ОУВС-гийн удирдлагаар батлуулсны дараа Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргана.

Коши Матайгаар ахлуулсан Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн мэргэжилтнүүдийн баг 2017 оны 2-р сарын 1-19-ний өдрүүдэд Улаанбаатар хотод ажиллаж, ОУВС-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх боломжтой эдийн засгийн бодлогын багц арга хэмжээний талаар Монголын эрх баригчидтай явуулж байсан хэлэлцээрийг үргэлжлүүлэн хийлээ. Хэлэлцээрийн үр дүнг дүгнэж, ноён Матай дараах мэдэгдэл хийв. Үүнд:

“Монгол Улсын Засгийн газар, ОУВС-гийн ажлын хэсэг 314.505 сая зээлжих тусгай эрх (ЗТЭ) (Монгол Улсын квотын 435 хувь) буюу ойролцоогоор 440 сая ам.долларын гурван жилийн хугацаатай өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (Extended Fund Facility, EFF)-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжих эдийн засаг, санхүүгийн хөтөлбөр дээр ажлын хэсгийн түвшинд тохиролцоонд хүрлээ. Засгийн газрын хөтөлбөрийг олон улсын бусад түншүүд мөн дэмжихээр төлөвлөж байна. Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк болон Япон, БНСУ зэрэг хоёр талт түншүүд нийтдээ 3 тэрбум хүртэл ам. долларын төсвийн болоод төслийн дэмжлэг үзүүлэхээр боллоо. Мөн Хятадын Ардын Банк Монголбанкинд нээсэн байгаа 15 тэрбум юанийн своп шугамын хугацааг дахин гурваас доошгүй жилээр сунгах боломжтойгоо илэрхийлээд байна.

“Ингэснээр хөтөлбөрийн нийт гадаад санхүүжилт 5.5 тэрбум ам. долларт хүрч, эдийн засаг, өрийн тогтвортой байдлыг сэргээхийн зэрэгцээ эдийн засгийн өндөр, тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах орчин нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй хамгийн эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааг хамгаалахад чиглэсэн Эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэхээр боллоо.

“Санхүүжилт олгох байгууллагууд баталгаагаа өгч, эрх баригчид урьдчилсан нөхцөлийг биелүүлэн, ОУВС-гийн Захирлуудын зөвлөл баталснаар энэхүү тохиролцоо

баталгаажна. Захирлуудын зөвлөл Монгол Улсын хүсэлтийг ирэх гуравдугаар сард авч хэлэлцэх төлөвлөгөөтэй байна.

“Монгол бол эрдэс баялгийн их баялагтай, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх өргөн боломжтой, залуу, эрч хүчтэй хүн амтай улс билээ. Тус улсын урт хугацааны ирээдүй олон боломжийг агуулж байгаа хэдий ч өнгөрсөн жилүүдэд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний үнэ огцом унаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурсанаас үүдэн Монголын эдийн засаг хүнд цохилтонд өртөөд байна. Эдийн засгийн уналтыг төсөв, мөнгөний тэлэх бодлогоор сөрөх оролдлого хэдэн жилийн дараа үр дүнгүй болох нь нотлогдсон бөгөөд эдийн засаг одоо зогсонги байдалд орж, өрийн хэмжээ их, гадаад валютын нөөц бага байгаа нь байдлыг улам хүндрүүлж байна.

“Төсвийн алдагдлыг бууруулах нь хамгийн гол зорилт болж байна. Өнгөрсөн хугацаанд төсвийг тэлэх бодлого баримталсан нь Монгол Улсын эдийн засагт одоо тулгараад байгаа хүндрэлүүд, өрийн их дарамтын үндсэн шалтгаан юм. Төсвийн алдагдлыг тасралтгүй бууруулахын зэрэгцээ зайлшгүй байх ёстой нийгмийн зардлууд хадгалагдан үлдэнэ. Тухайлбал, хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт илүү сайн чиглүүлсэнээр бий болох хэмнэлтийг бүгдийг нь нийгмийн хамгийн эмзэг бүлэгт зориулсан хүнсний талон хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зарцуулах юм. Мөн түүнчлэн, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хувь хүний орлогын албан татварыг илүү прогрессив буюу орлогын хэмжээтэй уялдан өсөх зарчимтай болгож, зөвхөн өндөр орлоготой иргэдэд ногдох татварын хувь хэмжээг өсгөнө.

“Монгол Улсын Хөгжлийн банк цаашид саяхан батлагдсан Хөгжлийн банкны тухай хуулинд заасны дагуу хараат бус, бие даасан, цэвэр арилжааны нөхцөлөөр үйл ажиллагаагаа явуулна. Монголбанк төсөвтэй адилтгах нэмэлт үйл ажиллагаа эрхлэхгүй бөгөөд Орон сууцны зээлийн хөтөлбөр зөвхөн эргэлтийн сангийн журмаар хэрэгжих болно. Түүнчлэн, концессийн тухай хууль тогтоомжийг шинэчилж, төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг сайжруулан, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй илүү уялдаатай болгоно.

“Төсвийн хариуцлагын одоогийн тогтолцоон дээр үндэслэн эрх баригчид төсвийн сахилга батыг хангахад чиглэсэн төсвийн шинэчлэлийн томоохон зорилтуудыг дэвшүүлээд байна. Тухайлбал, хараат бус, бие даасан төсвийн төсөөлөл гаргах, бодлогын шинэ арга хэмжээний санал дээр зардлын тооцоо хийх үүрэг бүхий Төсвийн зөвлөлийг байгуулах, төсвийн нийт зарлагын хэмжээг засгийн газар дангараа тогтоох эрх мэдэл олгох, төсвөөс зарлага санхүүжилт шаардсан аливаа арга хэмжээний саналыг засгийн газарт танилцуулахаас өмнө Сангийн яамны зөвшөөрлийг авсан байх хуулийн зүйл заалтууд оруулах юм.

“Үнийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд мөнгөний бодлого зохих хэмжээнд хатуу хэвээр байх болно. Гэхдээ цаашид эдийн засгийн байдал хэвийн болох үед гадаад секторын болоод инфляцийн үзүүлэлтүүдийг харгалзан бодлогын хүүг бууруулах нь зохистой болж магадгүй. Валютын ханш уян хатан хөдлөх боломжоор хангагдсан хэвээр байх бөгөөд валютын интервенцийг зөвхөн ханшийн огцом

савалгааг зөөлрүүлж, зах дээр эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх зорилгоор хийнэ. Монголбанкны эрх үүргийг тодорхой болгож, засаглалыг бэхжүүлэн, хараат бус байдлыг сайжруулах үүднээс Төв банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж УИХ-аар батлуулах нь тэргүүлэх зорилтуудын нэг байна.

“Банкны системийг бэхжүүлэх нь хөтөлбөрийн хамгийн чухал хэсэг юм. Энэ зорилтын хүрээнд банкуудыг тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг дэмжих чадвартай болгоно. Эрх баригчдийн эхний гол зорилт бол банкны системд иж бүрэн нарийвчилсан оношлогоо хийж, банкуудын санхүүгийн болоод эрсдэл даах чадварыг үнэлэх явдал юм. Үнэлгээний үр дүнд үндэслэн Монголбанк, шаардлагатай бол, банкууд дээр зохих бүтцийн өөрчлөлт, дахин хөрөнгөжүүлэлтийн арга хэмжээ авна. Энэ хүрээнд Монголбанкнаас зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэх бөгөөд Засгийн газар хадгаламжийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгохын төлөө ажиллана. Цаашилбал, эрх баригчид мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх орчинг бэхжүүлэх арга хэмжээг авна.

“Эрх баригчид уул уурхайн том төслүүдэд шинээр хөрөнгө оруулалт татаж, эдийн засгийг солонгоруулах, эдийн засгийн, нэн ялангуяа хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтцийн шинэчлэлийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх замаар эдийн засгийн үйл ажиллагаа, төлөвийг шууд сайжруулах зорилт тавин ажиллаж байна. Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банктай нягт хамтран ажилласны дүнд хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх шинэчлэлийн арга хэмжээнүүдийг тодорхойлсон.

“Эрх баригчдын бодлогын тохиргоо, бүтцийн шинэчлэлийн хөтөлбөрийг их хэмжээний гадаад санхүүжилтээр дэмжих бөгөөд энэхүү хөтөлбөр нь эдийн засгийг тогтворжуулж, тогтвортой, хүртээмжтэй, урт хугацааны өсөлтийн үндэс суурийг бий болгох учиртай. Эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал сайжирч, уул уурхайн томоохон төслүүд эдийн засгийн эргэлтэнд орсноор 2019 он гэхэд эдийн засгийн өсөлт 8 орчим хувьд хүрч нэмэгдэх төлөвтэй байна. Гадаад валютын нөөцийн хэмжээ уруудаж байсан замаасаа гарч, хөтөлбөр хэрэгжиж дуусах үед 3.8 тэрбум ам. долларт хүрнэ. Энэ нь импортын хэрэгцээний 6 гаруй сарыг хангах үзүүлэлт тул валютын нөөцийн хангалттай түвшин юм. Монгол Улс гадаад шоконд өртөхөөс өмнө 2012 онд валютын нөөц ийм түвшинд байсан. Төсвийн алдагдлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр цаашид банкны салбарын хувийн хэвшилд олгох зээлийн хэмжээг эдийн засгийн өсөлтийн тооцоолж буй түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Бодлогын эдгээр арга хэмжээний үр дүнд улсын өр хөтөлбөрийн хугацаанд буурч эхлэх болно.

“Хөтөлбөрт шаардлагатай байгаа санхүүжилтийн баталгааг гаргуулах үүднээс Засгийн газар гадаадын хувийн зээлдүүлэгчидтэй яриа хэлэлцээр эхлүүлэхээр төлөвлөж байгаагаа саяхан мэдэгдсэн нь өрийн тогтвортой байдлыг сэргээхэд дэмжлэг болох ёстой. Нэн ялангуяа, хөтөлбөрийн санхүүжилтийн тооцоог хийхдээ гадаадын хувийн зээлдүүлэгчдийн оролцоо хөтөлбөр хэрэгжих хугацаанд өрийн тогтвортой байдлыг

хангах хэмжээнд одоогийн түвшинд хадгалагдана гэж үзсэн. Мөн хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа нийт санхүүжилтийн хэрэгцээ зохистой түвшинд байна.

“Ажлын хэсгийн нэрийн өмнөөс халуун дотноор хүлээн авч, сүүлийн хэдэн сарын турш бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлэн, гойд сайн хамтран ажилласны үр дүнд өнөөдрийн тохиролцоонд хүргэж чадсан эрх баригчдад талархал дэвшүүлье.”